



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/650

Зуунмод

**Хоршооны үйл ажиллагаанд
гэрээт менежментийг ашиглах нь
Япон-Монголын хамтарсан зөвлөгөөн**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, Засгийн газраас 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил”, аймгийн 2022 оны “Ногоон хөгжил баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жилийн ажлын хүрээнд хоршооны хөгжлийг дэмжих зорилгоор “Хоршооны үйл ажиллагаанд гэрээт менежментийг ашиглах нь” Япон-Монголын хамтарсан зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулсугай.


2. Япон-Монголын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Тус арга хэмжээнд шаардагдах 8,330,500 (найман сая гурван зуун гучин мянга таван зуу) төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4. “Аймгийн хоршоологчдын зөвлөгөөн”-ий бэлтгэл ажлын төлөвлөгөө болон зөвлөгөөний хөтөлбөрийг батлуулж, товлосон хугацаанд өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэг (М.Отгонбат)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



8. Өдөр
Сая үүсгэл.
 15/11